Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төв нь  Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдал хүртээмж чанар, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээний стандарт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чандлан сахидаг чадварлаг эмч, мэргэжилтэн бүхий төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилго тавьсан байна.

Эрдэнэбулган сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийг эрт илрүүлэгд хамруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх
- Үйлчлүүлэгчдэд болон эмч ажилчдад ээлтэй орчин бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж тасралтгүй байдлыг хангах

### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас  санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан[1] 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан[2] тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж  үйлчилгээ гэсэн  арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:**

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

***Байгууллагын дотоод хяналтын талаар:*** Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 02 сарын 10-ны өдрийн А/11 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан ба дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг хавсралтаар баталсан. Дотоод хяналтын баг нь  2022 онд 3 заалт бүхий 8 ажлын төлөвлөгөө гаргаж графикт хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан байна.

Дотоод хяналтын баг нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улирлад нэг удаа хяналт хийж, тайланг удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

[1] *“Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”*
[2] “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. Тухайлбал: Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ. Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төв нь 2019 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын хэмжээнд боловсруулж байгууллагын даргаар батлуулсан баримт бичгийг ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,425.7 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 00.00 | 47,243.0 | -47,243.0 |
| Авлага | 56,251.9 | 0.0 | 56,251.9 |
| Бараа материал | 85,265.0 | 111,490.8 | -26,225.8 |
| Үндсэн хөрөнгө | 273,539.7 | 249,897.0 | 23,642.7 |
| **Нийт хөрөнгө** | **415,056.5** | **408,630.8** | **6,425.7** |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 415,056.5 | 408,630.8 | 6,425.7 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **415,056.5** | **408,630.8** | **6,425.7** |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө данс өмнөх оноос нэмэгдэж, авлагын данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 47,243.0 мянган төгрөгөөр үлдэгдэл нь эрүүл мэндийн даатгалын сангаас 4 багц буюу сэргээн засах, оношилгоо шинжилгээ, өрхийн эмчилгээ, гэрээр сувилахуйн санхүүжилт, үндсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтээ төлөвлөсний дагуу хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 26,225.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь корона вирусын үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлттэй холбоотой үлдэгдэл гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 23,642.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 36,362.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж 7,750.0 мянган төгрөг, Дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүй эмнэлгийн тоног төхөөрөмж 28,612.5 мянган төгрөгийн хөрөнгүүдийг тус тус орлогод авсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгал 515,800.5 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс санхүүжилт 60,106.7 мянга төгрөгийн санхүүжилт авахаар тооцсон. Нийт зарлагыг 575,907.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид 2021 оны 07 сарын 08 өдөр хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Орон нутгийн санхүүжилтийг тайлант онд 30,581.4 мянган төгрөгөөр *бууруулж* тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн даатгалаас гүйцэтгэлээр 597,697,2 мянган төгрөг, Орон нутгийн урсгал санхүүжилт 40,106.7 мянган төгрөгийг тус тус үйл ажиллагааны орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 639,553.1 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 47.243.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нэг иргэнээр тооцсон нормативаар | 312,901.8 | 312,439.3 | 462.5 | 99,8% |
| 2 | Үндсэн тусламж үйлчилгээ | 238,430.6 | 285.896.1 | -47,465.5 | 99,8% |
| 3 | Дээд шатны төсвөөс хуваарилсан | 1,351.0 | 1,351.0 | 0 | 100% |
| 4 | Төрийн байгууллагын тогтмол зард | 24,200.1 | 23,960.1 | -240.0 | 99% |
| 5 | Нийтлэг үйлчилгээ | 15,906.6 | 15,906.6 | 0 | 100% |
| | Дүн | 592,790.1 | 639,553.1 | -47,243.0 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Орон нутгийн төсвөөс цалин хөлс 14,139.2 ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэлд 1,767,4 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардал 787,3 мянган төгрөг, Түлш халаалтын зардал 20,812.7 мянган төгрөг, урсгал засвар 2,360.1 мянган төгрөг нийт 39,866.7 мянган төгрөг тус тус зарцуулсан 240.0 мянган төгрөгийг төвлөрүүлж 0,0 үлдэгдэлтэй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 36,781.3 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, үлдэгдлийг төрийн сангийн харилцах данс руу хааж бичилт хийж тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбулган **Эрүүл мэндийн төв**ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын Аудитын менежер Б.Тэгшдэлгэр, аудитор Г.Ичинхорлоо, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 550,704.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11,014.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 7,709.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага 47,243.0 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй 93,532.4 мянган төгрөгийн 8 гүйлгээ мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний дүн зөрүүтэй 17,280.8 мянган төгрөгийн 1 гүйлгээ нийт 110,813.2 мянган төгрөгийн 9 гүйлгээ мэдээлээгүй буюу зөрүүтэй мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн тул аудитаар зөвлөмж хүргүүллээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Эрүүл мэндийн даатгалын сангийн урсгал төсвийн санхүүжилтээс ТЕЗ-ийн шийдвэргүй суудлын автомашин 20,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан тул албан шаардлага, мөн эрүүл мэндийн төв шинэчилсэн нэр солиогүй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2 зөвлөмжийг өгч, тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 20,000.0 | 1 | 20,000.0 | 100 |
| Зөвлөмж | 2 | 0 | 2 | 0 | 100 |
| **Нийт дүн** | 3 | 20,000.0 | 3 | 20,000.0 | 100 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 25,354.2 мянган төгрөгийн тендергүй эмийн худалдан авалт хийсэн байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 188,367.8 мянган төгрөгийн алдаа[3] илэрснээс аудитын явцад 58,015.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 130,352.4 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

- ЭМД-аас 2021 оны ковидын авлага 56,251.9 мянган төгрөг авсан ба үүнийг 2022 оны Мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл ангийг буруу сонгож тайлагнасан нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх* заалтыг зөрчсөн, үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 1,763.5 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн *зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"*-ыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 130,352.4 мянган төгрөгийн зөрчил[4] илэрснээс, 130,352.4 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Бараа материалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс илүү хэмжээгээр 2,768.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1[5]" дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг их хэмжээгээр нөөцөлж, үр ашиггүй зардал гаргахгүй байх

**2. Бараа материал холбоотой асуудал**

---

[3] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[4] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

[5] "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

Илрүүлэлт:

Бараа материалын орлогыг тулгахад нийт 907.1 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 [6] гэсэн заалттай нийцээгүй ба "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж тайлагнахгүй байх

**3. Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Нийгмийн эрүүл мэндийн зардал болох 7,067.3 мянган төгрөгийн материалыг бараа материалын дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын 2006.11.27-ны өдрийн 388 тоот тушаалын 1 хавсралтын 4 бүлэг "Бараа материал" хэсгийн 4.21 дахь заалт "4.21 Бараа материалыг (хангамжийн зүйлийг) худалдан авсан үед: Дт. Хангамжийн материал Кт. Мөнгөн хөрөнгө / Дансны өглөг " гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авсан бараа материалыг тооцооны дансаар дамжуулж тайлагнаж байх.

**4.Худалдан авах ажиллагаатай холбоотой асууд**

Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 8,796.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтөлж тайлагнах

**5. Шилэн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй 93,532.4 мянган төгрөгийн 8 гүйлгээ мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний дүн зөрүүтэй 17,280.8 мянган төгрөгийн 1 гүйлгээ нийт 110,813.2 мянган төгрөгийн 9 гүйлгээ мэдээлээгүй буюу зөрүүтэй мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 202 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

[6] "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно."

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЭМД-аас 2021 оны ковидын авлагыг 2022 оны ЭМД-аас авсан санхүүжилт дээр нэмж Мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан | 1 | 56,251.9 | | | 1 | 56,251.9 | 1 | 56,251.9 | | | | |
| дансны харьцаа буруу хийгдсэн | 1 | 1,763.5 | | | 1 | 1,763.5 | 1 | 1,763.5 | | | | |
| Дүн | 2 | 58,015.4 | | | 2 | 58,015.4 | 2 | 58,015.4 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бараа материал тооцооны дансаар дамжуулаагүй | 1 | 7,067.3 | | | | | 1 | 7,067.3 | | | | |
| Сарын бодит хэрэглээнээс илүү материал нөөцөлсөн | 1 | 2,768.2 | | | | | 1 | 2,768.2 | | | | |
| Анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар гүйлгээ | 1 | 907.1 | | | | | 1 | 907.1 | | | | |
| Е баримтгүй гүйлгээ хийсэн | 1 | 8,796.6 | | | | | 1 | 8,796.6 | | | | |
| Дүн | 4 | 19,539.2 | | | | | 4 | 19,539.2 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй байна. | 1 | 93,532.4 | | | | | 1 | 93,532.4 |
| 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний илүү мэдээлсэн байна. | 0 | 17,280.8 | | | | | 0 | 17,280.8 |
| Дүн | 1 | 110,813.2 | | | | | 1 | 110,813.2 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Х.ДИЙМАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Л.МАГСАРЖАЛАМ